



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/160

Сүхбаатар сум

### Хяналт шалгалтын ажил зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "е", 29.1.3 "н", 30 дугаар зүйлийн 30.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, 16.2.10, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 31 дүгээр зүйлийн 31.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоол "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ийн 8.1.1 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Зарим газар нутгийг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай" 40 дүгээр тогтоолыг тус тус үндэсгэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгч, аж ахуйн нэгж, байгууллагуудын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих, гарсан зөрчлийг арилгуулах, таслан зогсоох ажлын удирдамжийг хазсралтаар баталсугай.

2. Удирдамжийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт шалгалтын ажлыг шуурхай гүйцэтгэж, ажлын явц үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/-т, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Түвшинтөгс/-т нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ